


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 02/16 8/226 03/6

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Адаацаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитаар барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг захиалагчийн хяналтын гэрээ байгуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4-т *барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1, 20-д заасан гэрээг байгуулж ажиллах*¹, Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 170 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.12-т *улсын болон орон нутгийн төсөв, гядаадын тээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр шалгуулсан гүйцэтгүүлж болно*, Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах арга хэмжээний" тухай А/407 дугаар захирамжийг тус тус зөрсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зорчсон, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлдэггүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэхдээ захиалагчийн хяналтын гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллах;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх арга хэмжээ зохион байгуулж, биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг дарга Ч.Уранчимэг, нягтлан бодогч Ч.Оюунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР  Т.БАТСАЙХАН

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР


Р.МӨНХТОГТОХ

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнсагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

0012041414